



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**
FINANCIAL REGULATORY COMMISSION
OF MONGOLIA

**ДААТГАЛЫН САЛБАРЫН 2018 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2018 ОН

Агуулга

1.ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ	2
1.1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	2
1.2.ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ	3
1.3.ДААТГАЛЫН ХУРААМЖ	4
1.4.ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР	6
1.5.ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА	7
1.6.ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА	9
1.7.ДАВХАР ДААТГАЛ	10
2.ЕРДИЙН ДААТГАЛ	10
2.1.ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖ	10
2.2.ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР	12
2.3.ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН АШИГТ АЖИЛЛАГАА	12
3.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ	12
3.1.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХУРААМЖ, НӨХӨН ТӨЛБӨР	12
3.2.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ	13
4.АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ	13
5.ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ	14
5.1.ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ	14
5.2.ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ	16

1.ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2018 оны байдлаар ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, давхар даатгалын 2, даатгалын зуучлагч 49, даатгалын хохирол үнэлэгч 27 компани даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж байна. Салбарын оролцогчдын тоон дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 1, 2-т харуулав.

Хүснэгт-1

Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

№		2017	2018
1	Ердийн даатгалын компани	15	15
2	Урт хугацааны даатгалын компани	1	1
3	Давхар даатгалын компани	1	2
4	Даатгалын төлөөлөгч	2893	2430
5	Даатгалын зуучлагч	42	49
6	Даатгалын хохирол үнэлэгч	29	27
7	Актуарч	21	28
8	Даатгалын үйл ажиллагаанд аудит хийх эрх бүхий аудитын компани	42	43
9	Даатгалын байгууллагад аудит хийх эрхтэй аудитор	130	141
	НИЙТ	3174	2736

Хүснэгт-2

Даатгалын компани, даатгалын мэргэжлийн оролцогч компаниудын салбарын тоо


№		2017	2018
1	Даатгалын компанийн салбар	239	246
2	Даатгалын компанийн төлөөлөгчийн газар	12	12
3	Даатгалын зуучлагч компанийн салбар	21	22
4	Даатгалын зуучлагч банкны салбар	188	253
5	Даатгалын хохирол үнэлэгч компанийн салбар	47	43
6	Даатгалын хохирол үнэлэгч компанийн төлөөлөгчийн газар	6	18
	НИЙТ	512	594

Хорооны 2018 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн 251 дүгээр тогтоолоор “Анд ДД” ХХК-д давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, 2018 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 123 дугаар тогтоолоор “Эн И Би консалтэнси” ХХК-д, 6 дугаар сарын 06-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор “Хост рок” ХХД-д, 6 дугаар сарын 29-ны өдрийн 250 дугаар тогтоолоор “Эм эн ай би” ХХК-д, 8 дугаар сарын 29-ний өдрийн 272 дугаар тогтоолоор “Капитрон банк” ХХК-д, 8 дугаар сарын 29-ний өдрийн 273 дугаар тогтоолоор “Марш брокер” ХХК-д, 9 дүгээр сарын 26-ны өдрийн 313 дугаар тогтоолоор “Эй Эс Ай Би” ХХК-д, 10 дугаар сарын 17-ны өдрийн 331 дүгээр тогтоолоор “Түвшин Оргил” ХХК-д, 11 дүгээр сарын 30-ны өдрийн 359 дүгээр тогтоолоор “Онолт Язгуур” ХХК-д тус тус даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Мөн 4 дүгээр сарын 04-ний өдрийн 124 дүгээр тогтоолоор “Хан-Үнэлэмж” ХХК-д даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Хорооны 2018 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 161 дүгээр тогтоолоор “Тэгш сонголт эстимэйт” ХХК-ийн, 2018 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 286 дугаар тогтоолоор “Лэндс” ХХК-ийн даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болгосон. 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 381 дүгээр тогтоолоор “Анд ДД” ХХК-ийн нэрийг “Хубилай ДД” ХХК болгож өөрчилсөн.

1.2.ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ


Тайлант хугацаанд даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө 331.94 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 87.2 тэрбум төгрөгөөр буюу 35.6 хувиар өссөн байна.

Дүрслэл-1



Даатгалын компаниудын нийт хөрөнгийн салбарын хэмжээнд эзлэх хувийг авч үзвэл ердийн даатгалын компаниудын хөрөнгө 76 хувь, давхар даатгалын компанийн хөрөнгө 21 хувь, урт хугацааны даатгалын компанийн хөрөнгө 3 хувийг тус тус эзэлж байна. Ердийн, урт хугацааны болон давхар даатгалын компаниудын хөрөнгө, салбарын нийт хөрөнгөд эзлэх хувийг дүрслэл 2 болон хүснэгт 3-т дэлгэрэнгүй харуулав.

Дүрслэл-2



Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө

№	Даатгалын компани	Нийт хөрөнгийн дүн /тэрбум төгрөгөөр/		Өсөлт/бууралт
		2017	2018	
1	Соёмбо даатгал ХХК	10.1	10.1	0.5%
2	Миг даатгал ХХК	16.1	17.4	7.9%
3	Монгол даатгал ХХК	33.2	37.6	13.2%
4	Мөнх даатгал ХХК	4.8	5.8	20.4%
5	Гэр даатгал ХХК	6.2	6.6	5.3%
6	Практикал даатгал ХХК	13.4	16.2	20.8%
7	Улаанбаатар хотын даатгал ХХК	6.1	7.1	15.6%
8	Номин даатгал ХХК	11.6	15.4	32.7%
9	Бодь даатгал ХХК	16.7	29.5	76.9%
10	Тэнгэр даатгал ХХК	19.3	23.6	22.1%
11	Ган зам даатгал ХХК	7.3	7.4	0.4%
12	Монре даатгал ХХК	6.7	9.0	35.4%
13	Ард даатгал ХК	11.7	21.0	79.1%
14	Нэйшнл лайф даатгал ХХК	7.8	8.9	14.3%
15	Мандал даатгал ХК	21.5	33.8	57.3%
16	Хаан даатгал ХХК	8.9	12.5	41.2%
17	Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК	43.4	48.6	12.0%
18	Хубилай давхар даатгал ХХК	-	21.6	100.0%
Нийт		244.7	331.9	35.6%

1.3. ДААТГАЛЫН ХУРААМЖ

Даатгалын компаниуд 2018 онд 178.7 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлсний 98.2 хувь буюу 175.5 тэрбум төгрөгийг ердийн даатгалын компаниуд, 0.97 хувь буюу 1.7 тэрбум төгрөгийг давхар даатгалын компаниуд, 0.8 хувь буюу 1.4 тэрбум төгрөгийг урт хугацааны даатгалын компани тус тус төвлөрүүлсэн байна. Тайлант хугацааны даатгалын нийт хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34.4 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд хураамжийн нийт орлогын сүүлийн 5 жилийн дундаж өсөлт 35.4 хувьтай байна.



Даатгалын хураамж

/сая төгрөгөөр/

№	Даатгалын компани	Даатгалын хураамжийн нийт орлого	Даатгалын хураамжийн буцаалт	Давхар даатгалын хураамжийн зардал	Даатгалын хураамжийн цэвэр орлого
1	Соёмбо даатгал ХХК	3 964.35	83.86	653.17	3 227.32
2	Миг даатгал ХХК	16 645.28	726.82	1 388.67	14 529.79
3	Монгол даатгал ХХК	30 408.04	554.73	8 478.80	21 374.51
4	Мөнх даатгал ХХК	1 154.22	3.30	-	1 150.91
5	Гэр даатгал ХХК	620.50	78.28	289.07	253.16
6	Практикал даатгал ХХК	10 945.63	421.19	977.33	9 547.11
7	Улаанбаатар хотын даатгал ХХК	1 196.82	0.54	-	1 196.28
8	Номин даатгал ХХК	6 446.95	226.59	342.31	5 878.05
9	Бодь даатгал ХХК	35 488.23	524.03	23 497.23	11 466.97
10	Тэнгэр даатгал ХХК	14 522.61	488.85	5 489.80	8 543.96
11	Ган зам даатгал ХХК	609.31	0.28	-	609.03
12	Монре даатгал ХХК	5 082.73	255.16	143.66	4 683.91
13	Ард даатгал ХК	13 001.38	228.47	3 163.48	9 609.44
14	Нэйшнл лайф даатгал ХХК	1 420.80	0.07	22.40	1 398.33
15	Мандал даатгал ХК	27 786.50	1 529.98	9 807.09	16 449.43
16	Хаан даатгал ХХК	7 673.14	291.60	234.82	7 146.72
17	Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК	1 738.28	17.53	825.30	895.45
18	Хубилай давхар даатгал ХХК	-	-	-	-
Нийт		178 704.77	5 431.27	55 313.13	117 960.37

Тайлант хугацаанд 178.7 тэрбум төгрөгний даатгалын хураамж төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.8%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Даатгалын хураамжийн нийт орлого /хэлбэрээр/

№	Даатгалын хэлбэр	Даатгалын хураамжийн нийт орлого /тэрбум төгрөгөөр/		Өсөлт/бууралт
		2017	2018	
1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	17.9	25.3	41.4%
2	Хөрөнгийн даатгал	36.7	42.0	14.3%
3	Авто тээврийн хэрэгслийн даатгал	18.5	28.1	51.7%
4	Ачааны даатгал	1.5	3.4	131.7%
5	Барилга угсралтын даатгал	7.4	8.0	8.5%
6	Газар тариалангийн даатгал	0.1	0.3	186.8%
7	Мал амьтдын даатгал	4.2	5.1	20.7%
8	Агаарын хөлгийн даатгал	1.5	1.3	-12.5%
9	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	0.4	0.5	22.4%
10	Хариуцлагын даатгал	10.8	15.0	39.3%
11	Санхүүгийн даатгал	3.2	3.5	9.4%
12	Зээлийн даатгал	2.9	3.3	12.5%
13	Итгэлцлийн даатгал	0.3	0.4	40.8%
14	Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	0.0	0.1	-
15	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	7.3	8.1	12.2%
16	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	30.4	33.0	8.3%
17	Хугацаат амьдралын даатгал	0.2	0.2	-32.1%
18	Хуримтлалын даатгал	0.1	0.2	159.8%
19	Тэтгэврийн даатгал	0.1	0.0	-57.6%
20	Эрүүл мэндийн даатгал	0.9	1.0	13.2%
Нийт		144.3	178.7	23.8%

1.5. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

Даатгалын тохиолдлын улмаас 2018 онд нийт 58.2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. “Миг даатгал” ХХК 13 тэрбум төгрөгийн, “Монгол даатгал” ХХК 8.6 тэрбум төгрөгийн, “Бодь даатгал” ХХК 6.2 тэрбум төгрөгийн, “Ард даатгал” ХК 6 тэрбум төгрөгийн, “Тэнгэр даатгал” ХХК 4.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь нийт нөхөн төлбөрийн 66.7 хувийг эзэлж байна. Нийт салбарын хэмжээнд авч үзвэл нөхөн төлбөрийн хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

№	Даатгалын компани	Нийт нөхөн төлбөрийн зардал /тэрбум төгрөгөөр/		Өсөлт/ Бууралт
		2017	2018	
1	Соёмбо даатгал ХХК	1.836	1.752	-4.6%
2	Миг даатгал ХХК	6.821	13.043	91.2%
3	Монгол даатгал ХХК	8.563	8.579	0.2%
4	Мөнх даатгал ХХК	0.062	0.152	143.6%
5	Гэр даатгал ХХК	0.413	0.308	-25.5%
6	Практикал даатгал ХХК	3.397	3.903	14.9%

7	Улаанбаатар хотын даатгал ХХК	0.145	0.496	241.7%
8	Номин даатгал ХХК	1.441	2.107	46.3%
9	Бодь даатгал ХХК	4.519	6.234	37.9%
10	Тэнгэр даатгал ХХК	4.847	4.928	1.7%
11	Ган зам даатгал ХХК	0.079	0.067	-15.5%
12	Монре даатгал ХХК	2.062	2.538	23.0%
13	Ард даатгал ХК	4.063	6.012	48.0%
14	Нэйшнл лайф даатгал ХХК	0.906	0.559	-38.2%
15	Мандал даатгал ХК	4.706	4.324	-8.1%
16	Хаан даатгал ХХК	1.379	2.689	95.0%
17	Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК	-	0.522	-
18	Хубилай давхар даатгал ХХК	-	-	-
Нийт		45.2	58.2	28.7%

Даатгалын компаниудын нөхөн төлбөрийн хэмжээг сүүлийн 5 жилийн байдлаар доорх хүснэгтэд харуулав.

Дүрслэл -4



Даатгалын компаниудын даатгалын нөхөн төлбөрийг даатгалын хэлбэрээр нь авч үзвэл жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаар 17 тэрбум төгрөгийн, авто тээврийн хэрэгслийн даатгалаар 13.2 тэрбум төгрөгийн, барилга угсралтын даатгалаар 8.5 тэрбум төгрөгийн, гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгалаар 7.5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг тус тус олгосон нь хамгийн өндөр дүнтэй байна.

Хүснэгт-7


№	Даатгалын хэлбэр	Нийт нөхөн төлбөрийн зардал /тэрбум төгрөгөөр/	
		2017	2018
1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	5.06	7.55
2	Хөрөнгийн даатгал	6.93	2.70

3	Авто тээврийн хэрэгслийн даатгал	8.51	13.15
4	Ачааны даатгал	2.15	0.22
5	Барилга угсралтын даатгал	1.61	8.47
6	Газар тариалангийн даатгал	0.21	0.92
7	Мал амьтдын даатгал	0.18	1.31
8	Агаарын хөлгийн даатгал	0.00	0.01
9	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	0.02	0.06
10	Хариуцлагын даатгал	0.86	2.98
11	Санхүүгийн даатгал	2.46	1.29
12	Зээлийн даатгал	0.70	1.46
13	Итгэлцлийн даатгал	0.03	0.01
14	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	0.09	0.46
15	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	15.51	17.06
16	Хугацаат амьдралын даатгал	0.06	0.08
17	Хуримтлалын даатгал	0.04	0.11
18	Тэтгэврийн даатгал	0.02	0.01
19	Эрүүл мэндийн даатгал	0.78	0.35
Нийт		45.2	58.2

1.6.ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниудын нийт хохирлын харьцаа 36.1 хувь байна. Үүнд давхар даатгалд төлсөн хураамж болон давхар даатгагчаас төлсөн нөхөн төлбөрийг оруулж тооцсон болно. Мөн даатгалын компаниудын хувьд даатгалын цэвэр хураамжийн орлогоос тооцсон орлогод тооцсон хураамж, даатгагчаас олгосон нөхөн төлбөрийн харьцаагаар тооцоход салбарын хэмжээнд хохирлын харьцаа 43.4 хувь байна.

Дүрслэл-5



Хүснэгт-8

Даатгалын компаниудын хохирлын харьцаа

№	Даатгалын компани	Орлогод тооцсон хураамж /сая төгрөгөөр/	Нөхөн төлбөрийн цэвэр зардал /сая төгрөгөөр/	Хохирлын харьцаа /цэвэр/
1	Соёмбо даатгал ХХК	3 482.3	1 417.9	40.7%
2	Миг даатгал ХХК	13 613.5	9 422.7	69.2%


3	Монгол даатгал ХХК	19 327.8	8 155.7	42.2%
4	Мөнх даатгал ХХК	1 091.3	151.9	13.9%
5	Гэр даатгал ХХК	508.8	307.8	60.5%
6	Практикал даатгал ХХК	8 408.8	3 532.8	42.0%
7	Улаанбаатар хотын даатгал ХХК	1 417.1	495.6	35.0%
8	Номин даатгал ХХК	5 489.3	2 048.4	37.3%
9	Бодь даатгал ХХК	11 576.7	4 302.8	37.2%
10	Тэнгэр даатгал ХХК	8 212.4	3 052.1	37.2%
11	Ган зам даатгал ХХК	579.1	66.6	11.5%
12	Монре даатгал ХХК	3 972.5	2 537.8	63.9%
13	Ард даатгал ХК	8 075.3	3 487.9	43.2%
14	Мандал даатгал ХК	11 931.7	3 286.1	27.5%
15	Хаан даатгал ХХК	5 921.9	2 676.4	45.2%
Нийт		103 608.5	44 942.5	43.4%

1.7. ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

Даатгалын компаниудын цэвэр ашиг 2018 онд 18.4 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 5.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт-9

№	Даатгалын компани	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) /сая төгрөгөөр/		Өсөлт/Бууралт
		2017	2018	
1	Соёмбо даатгал ХХК	24.7	341.7	1284.7%
2	Миг даатгал ХХК	109.6	133.4	21.7%
3	Монгол даатгал ХХК	1 179.6	94.5	-92.0%
4	Мөнх даатгал ХХК	575.7	294.1	-48.9%
5	Гэр даатгал ХХК	452.1	495.1	9.5%
6	Практикал даатгал ХХК	835.0	1 243.8	49.0%
7	Улаанбаатар хотын даатгал ХХК	64.2	244.9	281.8%
8	Номин даатгал ХХК	531.5	1 007.1	89.5%
9	Бодь даатгал ХХК	(1 026.8)	2 180.7	-312.4%
10	Тэнгэр даатгал ХХК	2 358.2	1 891.8	-19.8%
11	Ган зам даатгал ХХК	1 052.1	1 056.0	0.4%
12	Монре даатгал ХХК	(481.5)	109.8	-122.8%
13	Ард даатгал ХК	1 124.0	1 263.4	12.4%
14	Нэйшнл лайф даатгал ХХК	181.4	93.0	-48.7%
15	Мандал даатгал ХК	1 102.5	3 868.3	250.9%
16	Хаан даатгал ХХК	800.5	64.9	-91.9%
17	Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК	4 319.7	4 057.0	-6.1%
18	Хубилай давхар даатгал ХХК	-	-	-
Нийт		13 202.4	18 439.3	39.7%



1.8. ДАВХАР ДААТГАЛ

Сүүлийн 4 жилийн байдлаар ердийн даатгалын компаниудын давхар даатгалын хураамжийн өсөлт бууралтыг дараах дүрслэлээр харуулав.



2.ЕРДИЙН ДААТГАЛ

2018 онд 15 ердийн даатгалын компани, тэдгээрийн 246 салбар, 12 төлөөлөгчийн газар Улаанбаатар хот, орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

2.1.ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖ

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниуд нийт сайн дурын 15 болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хэлбэрээр нийт 175.5 тэрбум төгрөгийн хураамж төвлөрүүлж, үүнээс давхар даатгалын хураамжид 54.5 тэрбум төгрөг төлж, 5.4 тэрбум төгрөгийн хураамжийн буцаалт хийж 115.7 тэрбум төгрөгийн хураамжийн цэвэр орлоготойгоор тайлагнасан байна. Даатгалын компаниудын даатгалын хураамжийн талаар 1.4 дэх хэсэгт дэлгэрэнгүй

танилцуулсан. Ердийн даатгалын хураамжийн нийт орлогыг даатгалын хэлбэрээр ангилж, дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт-10

№	Даатгалын хэлбэр	Даатгалын хураамжийн нийт орлого /тэрбум төгрөгөөр/	Хураамжийн нийт орлогод эзлэх хувь
1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	25.3	14.4%
2	Хөрөнгийн даатгал	41.9	23.9%
3	Авто тээврийн хэрэгслийн даатгал	28.1	16.0%
4	Ачааны даатгал	3.4	2.0%
5	Барилга угсралтын даатгал	8.0	4.6%
6	Газар тариалангийн даатгал	0.1	0.1%
7	Мал амьтдын даатгал	3.5	2.0%
8	Агаарын хөлгийн даатгал	1.3	0.7%
9	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	0.5	0.3%
10	Хариуцлагын даатгал	15.0	8.5%
11	Санхүүгийн даатгал	3.5	2.0%
12	Зээлийн даатгал	3.3	1.9%
13	Итгэлцлийн даатгал	0.4	0.2%
14	Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	0.05	0.03%
15	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	8.1	4.6%
16	Жолоочийн хариуцлагын даатгал	33.0	18.8%
ДҮН		175.5	100.0

Дүрслэл-8



2.2.ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниуд нийт 57.1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг даатгуулагчид олгосноос 10.6 тэрбум төгрөгийг давхар даатгагч, 1.6 тэрбум төгрөгийг буруутай этгээд, 44.9 тэрбум төгрөгийг даатгагч нар тус тус төлсөн байна. Ердийн даатгалын компаниудын олгосон нөхөн төлбөр нь салбарын нийт нөхөн төлбөрийн 98.1 хувийг эзэлж байна.

Дүрслэл-9



2.3.ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН АШИГТ АЖИЛЛАГАА


Даатгалын компаниудын 2018 оны ашигт ажиллагааг 1.7 дахь хэсэгт дэлгэрэнгүй харуулсан бөгөөд ердийн даатгалын компаниуд тайлант хугацааны цэвэр ашиг 14.3 тэрбум төгрөг, хуримтлагдсан ашиг 22.6 тэрбум төгрөг байна.

3.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

3.1.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХУРААМЖ, НӨХӨН ТӨЛБӨР

Тайлант хугацаанд “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн даатгалын хураамжийн нийт орлого 1.42 тэрбум төгрөг, нийт нөхөн төлбөр 559.3 сая төгрөгт хүрч, урт хугацааны даатгагчийн хураамжийн нийт орлого, нийт нөхөн төлбөрийн харьцаа 39.4 хувьтай байна. Тайлант хугацааны урт хугацааны даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, тэдгээрийн харьцааг сүүлийн жилүүдтэй харьцуулав.

Дүрсэл-10



3.2 ДАВХАР ДААТГАЛ

“Нэйшнл лайф даатгал” ХХК нь давхар даатгалын хураамжид тайлант хугацаанд 22.4 сая төгрөгийг зарцуулсан байна. Урт хугацааны даатгалын сүүлийн 4 жилийн давхар даатгалын хураамжийг дүрслэлээр харуулав.

Дүрслэл-11




4.АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

2018 онд ердийн даатгалын 15 компани жолоочийн хариуцлагын албан журмын даатгал /цаашид “жолоочийн хариуцлагын даатгал” гэх/-ын үйл ажиллагаа эрхэлж 33 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 2.53 тэрбум төгрөгөөр буюу 8.3%-иар өссөн байна.

№	Даатгалын компани	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамжийн орлого /сая төгрөгөөр/		Өсөлт/Бууралт
		2017	2018	
1	Соёмбо даатгал ХХК	1 488.9	1 365.0	-8.3%
2	Миг даатгал ХХК	4 681.0	5 155.6	10.1%
3	Монгол даатгал ХХК	5 609.9	6 339.6	13.0%
4	Мөнх даатгал ХХК	492.7	625.0	26.9%
5	Гэр даатгал ХХК	747.6	177.1	-76.3%
6	Практикал даатгал ХХК	2 475.7	2 473.1	-0.1%
7	Улаанбаатар хотын даатгал ХХК	8.0	8.5	5.8%
8	Номин даатгал ХХК	2 086.2	2 144.5	2.8%
9	Бодь даатгал ХХК	3 743.6	4 207.0	12.4%
10	Тэнгэр даатгал ХХК	2 288.2	2 240.7	-2.1%
11	Ган зам даатгал ХХК	25.4	33.9	33.2%
12	Монре даатгал ХХК	2 316.0	2 590.2	11.8%
13	Ард даатгал ХК	1 780.9	2 445.1	37.3%
14	Мандал даатгал ХК	1 355.8	544.6	-59.8%
15	Хаан даатгал ХХК	1 345.5	2 629.8	95.5%
Нийт		30 445.4	32 979.9	8.3%

Тайлант хугацаанд даатгалын компаниуд жолоочийн хариуцлагын даатгалаар нийт 17.06 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Албан журмын болон сайн дурын даатгалын хураамжийн нийт орлого, нийт нөхөн төлбөрийг доорх дүрслэлээр харьцуулж харуулав.

Дүрслэл-12



5.ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

5.1.ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ

2018 онд тусгай зөвшөөрөлтэй нийт 49 даатгалын зуучлалын компаниас 1 компани тайлангаа ирүүлээгүй байна. Тайлант хугацаанд 34 даатгалын зуучлагч компани, 9 банк даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулж ердийн даатгалын 12, урт хугацааны даатгалын 2 хэлбэрийн

даатгалын бүтээгдэхүүний гэрээ зуучилж, 48.8 тэрбум төгрөг буюу салбарын хураамжийн нийт орлогын 27.3 хувийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт-12
/сая төгрөгөөр/

№	Даатгалын зуучлагч компани	Зуучилсан даатгалын хураамжийн орлого	Даатгалын зуучлалын шимтгэлийн орлого
Давхар даатгалын зуучлагч компани			
1	Асимон брокерс	1 414.7	163.9
2	Ачит ундарга	651.5	112.2
3	Монголиан интернэшнл брокерс	1 004.4	74.5
4	Си эн эн икс	1 687.0	490.7
5	Хүннү сизл	0.4	0.1
6	Ай Ай Би	110.2	6.2
7	Ковер хилл	357.6	41.8
Даатгалын зуучлагч компани			
8	АМЕ	1 378.2	102.0
9	Нэйшнл эженси	597.4	80.2
10	Эм жи ай би	336.0	74.7
11	Лоялти солюшн	1 529.4	184.2
12	Ренессанс групп	276.7	46.7
13	Смарт брокерс	2 022.7	571.0
14	Эрсдэлийн шийдэл	699.1	200.0
15	Эс ай би эс	1.4	0.2
16	Сүрэг хараацай	2 006.9	427.2
17	Ваяснью Солюшн	1 345.4	393.0
18	Ар Эм Ай Би	-	-
19	Дэвжих дэлгэрэх холдинг	433.6	84.5
20	Монгол бичээч зууч	542.8	138.1
21	Мастер шийдэл	50.4	16.4
22	Цагаан гэрэлт	155.6	33.9
23	Арм интернэшнл	21.0	2.1
24	Эл Би брокерэж	800.1	164.6
25	Тус брокерс	30.6	2.5
26	Монголиан иншуранс Брокерейж	5.6	1.6
27	Тод капитал	828.6	173.9
28	Бест солюшн	568.4	89.3
29	Эс Ти Ди	802.8	243.5
30	Ивээлт-Очир	-	-
31	Соёмбо брокер	8.7	1.6
32	Чанд финтех	33.0	7.9
33	Тэгш брокерс	2 495.5	176.2
34	Хост рок		
35	Эн И Би Консалтэнси	16.6	3.0
36	Эм эн ай би	121.1	24.6
37	Марш брокерс	-	-
38	Түвшин Оргил	2.3	-
39	Онолт язгуур	-	-
Даатгалын зуучлагч банк			
40	Хаан банк	4 995.5	1 044.5

41	ХасБанк	2 419.5	491.2
42	Төрийн банк	4 419.7	1 006.9
43	Капитал банк	83.7	17.0
44	Худалдаа хөгжлийн банк	5 747.8	959.2
45	Ариг банк	121.2	24.3
46	Голомт банк	6 234.0	874.2
47	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	2 061.4	437.9
48	Улаанбаатар хотын банк	395.9	59.4
49	Капитрон банк	-	-
Нийт		48 814.2	9 047.0

Тэмдэглэл:(-)-үйл ажиллагаа эрхлээгүй,(#N/A)-Фина системд тайлан ирүүлээгүй

2018 онд даатгалын зуучлагч компаниуд 4.1 тэрбум төгрөгийн, даатгалын зуучлагч банкууд 4.9 тэрбум төгрөгийн даатгалын зуучлалын шимтгэлийн орлого тайлагнасан бөгөөд нийт даатгалын зуучлалын шимтгэлийн орлого 9.05 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 29.1 хувиар өссөн байна.

Дүрслэл-13



5.2. ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

Тайлант хугацаанд 22 компани санхүүгийн болон нэмэлт тайлант ирүүлсэн бөгөөд нийт 1.03 тэрбум төгрөгийн даатгалын хохирол үнэлгээний орлого төвлөрүүлжээ. Нийт дүнгээрээ даатгалын хохирол үнэлгээний орлого нь өмнөх оны мөн үеэс 33.7 хувиар өссөн байна.

Хүснэгт-13
/төгрөгөөр/

№	Даатгалын хохирол үнэлгээний компани	Даатгалын хохирлыг үнэлсэн тоо	Даатгалын хохирол үнэлгээний орлого /сая төгрөгөөр/
1	Хөрөнгө үнэлгээний төв	13	0.53
2	Итгэлт эстимэйт	179	7.141818

3	Вендо	2576	124.3483546
4	Бэст эстимэйт	54	33.49727273
5	Гэрэгэ эстимэйт	1871	56.98528
6	Файн эстимэйт	0	0
7	Арвижих эстимэйт	275	39.938158
8	Ашид билгүүн	10003	370.7168
9	Фэйр валуэшн	499	15.25949
10	Арга билэг эстимэйт	#N/A	#N/A
11	Хос стандарт	226	3.85
12	Сэлэнгэ эстимэйт	#N/A	#N/A
13	Мастер Үнэлгээ	1243	60.59572727
14	Ухаашүрт консалтинг	1474	49.81999999
15	Кости эстимэйт	2285	45.35463637
16	Хөрөнгө эстимэйт	1040	38.99053
17.00	Хас үнэлгээ	389	13.147
18	Банхас	1115	15.4805
19	Аа аперейзал	125	3.99
20	Тэнцвэр эстимэйт	2165	71.06309091
21	Виннэрвэй	28	1.2931
22	Мөнх эстимэйт	132	42.807604
23	Үнэлгээ консалтинг	#N/A	#N/A
24	Тод үнэлгээ	564	17.616711
25	Далайван аудит	3	10.1
26	Голд стандарт эстимэйт	133	5.8
27	Хан-Үнэлэмж	#N/A	#N/A
Нийт		26 392	1028.33

Тэмдэглэл: (-)-үйл ажиллагаа эрхлээгүй, (#N/A)-Фина системд тайлан ирүүлээгүй

-ДААТГАЛЫН ГАЗАР-